



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Г Нисэх буудлын хориотой болон  
хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийн  
хураамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9, 10 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалын 14 дүгээр хавсралтаар баталсан “Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журам”-ын 3.1, 3.2.1.15 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийн хураамжийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Тушаалыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдэж ажиллахыг Аюулгүй байдал, хамгаалалтын алба (Б.Сэр-Од)-нд, холбогдох журмын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээллийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нисэх буудлуудын үйлчилгээний газар (С.Нацагдорж), Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн A/168 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТСАЙХАН



1723 01 0066



Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2023 оны 01 дүгээр сарын 01.-ны өдрийн  
01.01.. дүгээр тушаалын хавсралт

**НИСЭХ БУУДЛЫН ХОРИОТОЙ БОЛОН ХАМГААЛАГДСАН  
БҮСЭД НЭВТРЭХ ҮНЭМЛЭХИЙН ХУРААМЖ**

А.Хувь хүн			
№	Нэвтрэх үнэмлэх хүсэгч	Хугацаа	Хураамж (төгрөгөөр)
1.	Иргэний нисэхийн байгууллагууд, нисэхийн үйл ажиллагаанд оролцогчид болон бусад байгууллагын ажилтнууд	2 жил	22,000
		30-90 хоног	11,000
Б.Тээврийн хэрэгсэл			
1.	Авиа компаниуд болон гаднын байгууллагын технологи үйлдвэрлэлийн тээврийн хэрэгсэл (Хориотой, хамгаалагдсан бүс)	1 жил	165,000
		30-90 хоног	55,000
2.	Ажил үүргийн зайлшгүй шаардлагаар нэвтрэх Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа алба салбарын ажилтан, албан хаагчдын хувийн тээврийн хэрэгсэл (Хамгаалагдсан бүс)	1 жил	55,000
		30-90 хоног	33,000
3.	Тээврийн хэрэгсэл өөрчлөгдсөн тохиолдолд (тээврийн хэрэгслийн дугаар, марк солих)	1 жил	11,000
		30-90 хоног	

**Нэмэлт:**

1.Нэвтрэх үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгохдоо үнэлгээг 2 (хоёр) дахин нэмэгдүүлнэ.

2.Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа алба, салбарын ажилтан алба хаагчдын хувийн тээврийн хэрэгсэлд нэвтрэх үнэмлэх олгохдоо харьяа газрын даргын тодорхойлолтыг үндэслэнэ.

3.Алба салбарын захиргааны нэгж нь тухайн ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, албан тушаал өөрчлөгдсөн, удаан хугацаагаар чөлөөтэй, сургалтад сурч байгаа зэрэг мэдээллийг улирал тутам Аюулгүй байдал, хамгаалалтын албанад бичгээр мэдэгдэнэ.

---Оо---